



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.06 № МНАТ-2024/13-УТА НА-63

танай _____-ны № _____-т

**ЕРӨӨ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМД**

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Иргэний хөдөлгөөний намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-

2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Иргэний хөдөлгөөний намын Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэний хөдөлгөөний намын мөрийн хөтөлбөр / ...⁴ хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Ерөө сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН
СЭЛЭНГЭ АЙМГИЙН БОЛОН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛИЙН “НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ
ХӨГЖИЛ” МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
“НҮҮДЛИЙН СОЁЛТ ДЭЛХИЙН УЛС”
“НҮҮДЭЛЧДИЙН ИХ УЛС МОНГОЛ”
“ҮНДЭСНИЙ СОЁЛТ НҮҮДЭЛЧИН МОНГОЛ АЙМАГ”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**1) ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН
“НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖИЛ”
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ**


Иргэний хөдөлгөөний намын 2024 оны ээлжит сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль эрх зүйн үндэслэл:

- “Иргэний хөдөлгөөний” гэх улс төрийн нам нь үндэснийхээ эрх ашгийг дээдлэн, Монгол Улсын “Үндсэн Хууль”-аар олгогдсон ард түмнийхээ улс төрийн хуульчлагдсан эрх ашгийг хамгаалан, намын гишүүдийнхээ Монгол Улсын “Үндсэн Хууль”-аар олгогдсон улс төрийн хуульчлагдсан эрх ашгийг төлөөлөн Монгол Улсын бүхий л хууль тогтоомжуудыг ёсчлон сахиж, хуулиар олгогдсон улс төрийн эрх, үүрэг, хариуцлагаа бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажиллах болно.

гэж илэрхийлснийг Иргэний хөдөлгөөний намын аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль эрх зүйн ерөнхий үндэслэл гэж үзнэ.

**2) ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН
“НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖИЛ”
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ХУУЛЬ ЁС ЗҮЙН ЗАРЧИМ**

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль ёс зүйн зарчим:



- Монгол Улсын “Үндсэн Хууль”, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг дээдлэн сахиж, дагаж мөрдөн ажиллана;
- Төрийн бүрэн бүтэн байдал, засаглалын залгамж чанарыг дээдлэн сахиж ёсчлон биелүүлж ажиллана;
- Аймаг, орон нутгийн эрх ашиг, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг дээдлэн сахиж хариуцан хамгаалж ажиллана;
- Орон нутгийн эрх ашиг, үндэсний эв нэгдлийг дээдлэн сахиж, батлан хамгаалж ажиллана;
- Орон нутгийн иргэдийн эрх ашиг, эв нэгдлийг дээдлэн сахиж, хайрлан хамгаалж ажиллана;
- Хүний эрх, эрх ашиг, хүн төрөлхтний эв нэгдлийг дээдлэн сахиж нийтлэг хууль ёс, ёс зүй, ёс суртахуун, өөрийн болон бусад олон улс үндэстнүүдийн ёс, зан заншлыг хүндэтгэн эрхэмлэж ажиллана;
- Хөрш улс орон болон бусад гадаад улс орнуудын эрх ашиг, дэлхийн бүхий л улс орнуудын хамтын эв нэгдлийг дээдлэн сахиж харилцан үр ашигтай хамтран ажиллана;
- Орон нутгийн иргэдийнхээ өмнө хүлээсэн хуульчлагдсан эрх, үүрэг хариуцлагаа дээдлэн сахиж нэр төртэйгөөр бүрэн төгс биелүүлж ажиллана;
- Дэлхийн хүн төрөлхтний нэгдэн оршихуйн өмнө хүлээсэн үүргээ бүрнээ хүлээн зөвшөөрч хүн байгалийн хүйн холбоо байгаль экологийн тэнцвэртэй тогтвортой хөгжлийг дээдлэн сахиж бүрэн дүүрэн ханган ажиллана;
- Шинжлэх ухааны бүхий л хэм хэмжигдэхүүнээр нотлогдсон үндэсний эрх зүй нь орон нутаг хөгжихийн үндэс болохыг дээдлэн сахиж баримтлан ажиллана;
- Хууль эрх зүйн бүхий л хэм хэмжигдэхүүнээр батлагдсан хөдөлмөрлөх эрх зүй нь нийгэм хөгжихийн үндэс болохыг дээдлэн сахиж баримтлан ажиллана;

- Улс төрийн намуудын эрх ашиг, улс төрийн намуудын эв нэгдлийг дээдлэн сахиж, эрх тэгш хамтран ажиллана;
- Иргэний хөдөлгөөний намын гишүүдийнхээ эрх ашиг, эв нэгдлийг дээдлэн сахиж, бататган бэхжүүлж ажиллана.

гэж илэрхийлснийг Иргэний хөдөлгөөний намын аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль ёс зүйн ерөнхий зарчим гэж үзнэ.



**3) ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН
“НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖИЛ”
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМ**



Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль эрх зүйн зарчим

Иргэний хөдөлгөөний нам нь хуулиар олгогдсон улс төрийн эрх, үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэхдээ:

- Монгол Улсын “Үндсэн Хууль”, Монгол Улсын бүхий л хууль тогтоомжуудыг хуульчлан сахиж,
- Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг ёсчлон сахиж,
- “Монгол Улсын улс төрийн намуудын тухай хууль”-ийг хуульчлан биелүүлж,
- Монгол Улсын “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль” болон холбогдох бүхий л хууль тогтоомжуудыг хуульчлан мөрдөж,
- Монгол Улсын Их Хурлаар батлагдсан “Алсын Хараа–2050” “Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого”-д нийцүүлэн,
- “Монгол Улсын Аудитын тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган,
- “Монгол Улсын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-ийг хуульчлан хэрэгжүүлж ажиллах болно.

гэж илэрхийлснийг Иргэний хөдөлгөөний намын аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль эрх зүйн ерөнхий зарчим гэж үзнэ.



**4) ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН
“НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖИЛ”
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

ЕРӨНХИЙ ЗОРИЛГО

**“Алсын Хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн
бодлогын хэрэгжилтийг хангах**

**“ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН НЭГДСЭН ЭРХ ЗҮЙН ОРЧИН”
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

ЗОРИЛГО 1.

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ бодлогын хэрэгжилтийг хангах

**“ҮНДЭСНИЙ СОЁЛЫН ХӨГЖЛИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН”
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

ЗОРИЛГО 2.

ХҮНИЙ ХӨГЖИЛ бодлогын хэрэгжилтийг хангах

**“МОНГОЛ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН”
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

ЗОРИЛГО 3.

АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА бодлогын хэрэгжилтийг
хангах

**“АМЬДРАЛЫН ЧАНАРЫН ХӨГЖЛИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН”
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

ЗОРИЛГО 4.

ЭДИЙН ЗАСАГ бодлогын хэрэгжилтийг хангах

**“ОЛОН ТУЛГУУРТ ЭДИЙН ЗАСГИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН”
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

ЗОРИЛГО 5.

ЗАСАГЛАЛ бодлогын хэрэгжилтийг хангах

**“ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛЫН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН”
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**



ЗОРИЛГО 6.

НОГООН ХӨГЖИЛ бодлогын хэрэгжилтийг хангах

**“БАЙГАЛЬ ЭКОЛОГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН”
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

ЗОРИЛГО 7.

АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ бодлогын хэрэгжилтийг хангах

**“НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН”
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

ЗОРИЛГО 8.

БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ бодлогын хэрэгжилтийг хангах

**“БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН”
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

**НЭГДСЭН ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖЛИЙН
ТӨЛӨӨ!**

НҮҮДЛИЙН СОЁЛТ ДЭЛХИЙН УЛС”

“НҮҮДЭЛЧДИЙН ИХ УЛС МОНГОЛ”


“ҮНДЭСНИЙ СОЁЛТ НҮҮДЭЛЧИН МОНГОЛ АЙМАГ”

ЗОРИЛГО: “Нэгдмэл Эрх Зүйт Монгол Хөгжлийн төлөө” мөрийн хөтөлбөрийн хүрээнд

1. Дэлхийн Соёлын Ирээдүй Нүүдэлчин Монгол;
2. Экологийн цэвэр төгс хөгжилт Дэлхийн Монгол;
3. Дэлхийн Санхүү Эдийн Засгийн Сонгодог хөгжил Их Монгол улс

АРГА ЗАМ: “Нэгдмэл Эрх Зүйт Монгол Хөгжлийн төлөө” мөрийн хөтөлбөрийн хүрээнд

1. Нүүдлийн соёл иргэншилт үндэсний хөгжлийн нэгдсэн эрх зүйн зохицуулалт, сонгодог эко хөгжлийн бодлогыг удирдан хөгжүүлэх;
 - Үндэсний хөгжлийн нийгэм соёлын эрх зүйн зохицуулалтыг ёсчлон биелүүлж удирдан хөгжүүлэх;
 - Үндэсний хөгжлийн нийгэм улс төрийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон биелүүлж удирдан хөгжүүлэх;



- Үндэсний хөгжлийн нийгэм эдийн засгийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон биелүүлж удирдан хөгжүүлэх;
- 2. Бүсчлэн хөгжүүлэх нэгдмэл эрх зүйн зохицуулалт, сонгодог геополитикийн бодлогыг удирдан хөгжүүлэх;
 - Бүсчилсэн хөгжлийн нийгэм соёлын эрх зүйн зохицуулалтыг ёсчлон биелүүлж удирдан хөгжүүлэх;
 - Бүсчилсэн хөгжлийн нийгэм улс төрийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон биелүүлж удирдан хөгжүүлэх;
 - Бүсчилсэн хөгжлийн нийгэм эдийн засгийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон биелүүлж удирдан хөгжүүлэх;
- 3. Үндэсний соёлт нүүдэлчин Монгол аймгийн хөгжлийн нэгдмэл эрх зүйн зохицуулалт, сонгодог Монгол хөгжлийн бодлогыг удирдан хөгжүүлэх;
 - Нүүдэлчин Монгол Аймгийн хөгжлийн нийгэм соёлын эрх зүйн зохицуулалтыг ёсчлон биелүүлж удирдан хөгжүүлэх;
 - Нүүдэлчин Монгол Аймгийн хөгжлийн нийгэм улс төрийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон биелүүлж удирдан хөгжүүлэх;
 - Нүүдэлчин Монгол Аймгийн хөгжлийн нийгэм эдийн засгийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон биелүүлж удирдан хөгжүүлэх.

ҮР ДҮН: “Нэгдмэл Эрх Зүйт Монгол Хөгжлийн төлөө” мөрийн хөтөлбөрийн хүрээнд

1. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол Улс;
2. Дэлхийн Нийгэм Улс Төрийн Ирээдүйн Хараа Монгол Улс;
3. Дэлхийн Санхүү Эдийн Засгийн Ирээдүйн Шийдэл Монгол Улс;